

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН СУМЫН УЛСЫН ТЭРГҮҮНИЙ 3-Р ЦЭЦЭРЛЭГИЙН ТАНИЛЦУУЛГА



МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН АЛСЫН ХАРАА

Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээгээр манлайлж, чанар, сэтгэл ханамжийг эрхэмлэн дээдэлдэг, олон нийтэд үнэлэгдэхүйц байгууллага болно.

МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

“Бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд амжилттай бэлтгэхэд бидний эрхэм зорилго оршино “

МАНАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

- ✓ Хүүхэд бүрийн хөгжилд цогц хандан тэднийг хайрлан хүндэлж, танин мэдэхүйн онцлог дээр нь тулгуурлан хөгжүүлнэ.
- ✓ Хүүхэд бүрийн хүсэл сонирхол, сонголтыг хүндэтгэж , өөртөө итгэлтэй байдлыг нь дэмжинэ.
- ✓ Хүүхдийн хувийн зан чанарын онцлогийг харгалзаж өөрийнх нь хүчийг мэдрүүлнэ.

ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН ЗАМ

Тус цэцэрлэг нь анх 1968 онд 2 бүлэг ,50 хүүхэдтэй 8 ажилчинтайгаар байгуулагдсан ба түүнээс хойш сургуулийн өмнөх насны хүүхдэд СӨБ олгох үйл ажиллагааг үе үеийн багш ажилчдын хөдөлмөр үйл ажиллагаагаар одоог хүртэл хүргэн ажиллаж байна . Тус цэцэрлэг нь 1985 оноос 160 хүүхдийн хүчин чадалтай зориулалтын барилгад шилжин орж ажилласнаар СӨН-ны хүүхдийг хамран сургах хүрээ хүртээмж нэмэгдэн СӨНХ-дэд СӨБ олгох үйл ажиллагааны хөгжил ,сургалтын арга зүйн агуулга ,багш ажилчдын боловсролын түвшин хөдөлмөрийн чадавхи жилээс жилд дээшлэн ажлын туршлага арга барил , мэргэжлийн ур

чадвар ,мэдлэг дадлага хуримтлуулан Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, ,Боловсролын тухай багц хууль, Сургуулийн өмнөх боловсролын хууль, ,Төрийн албаны тухай хууль, Аймаг орон нутгийн боловсролыг хөгжүүлэх тухай бодлого болон бусад холбогдох хууль тогтоомжинд нийцүүлэн сургалт үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна .

ХАМРАН СУРГАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ /сүүлийн 10 жилээр /

